ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 04. 18 № 904

танай ________________-ны № ________________-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН
НАМЫН ХОРООНД

Хандивын тайлангийн дүгнэлт
хүргүүлэх тухай

**Хандивын тайлангийн дүгнэлт**

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Иргэний зориг ногоон намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Иргэний зориг ногоон намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

Сүхбаатар дүүргийн Иргэний зориг ногоон нам ээлжит бус нөхөн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэж тайлагнаагүй байна.

Сүхбаатар дүүргийн Иргэний зориг ногоон намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хувийг: Нийслэл, Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2.. хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нам, эвслээс нэр дэвшүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,
дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-1

**Аймаг. Нийслэл. Сум.дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт**

**ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ**

/мян.төг/

| Д/Д | Иргэний овог нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл | | | | Хандив өгсөн огноо | Хандивын мөнгөн дүн | Хандив хүлээж авсан | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Регистрийн дугаар | Нас | Оршин суугаа хаяг | Утасны дугаар | | | Банкны нэр | Дансны дугаар | |
| Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон | | | | | | | | | | |
| 1 | байхгүй | | | | | | 0 | | | |
| 2 | байхгүй | | | | | | | | | |
| Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд | | | | | | | | | | |
| 1 | байхгүй | | | | | | 0 | | | |
| 2 | байхгүй | | | | | | | | | |

***Санамж*** *: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.*

Тамга, тэмдэг

Хянасан : Ерөнхий нарийн бичгийн дарга ................................/С. Батбаатар/

2023.04.11

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,
дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-2

**Аймаг. Нийслэл. Сум.дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт**

**ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ**

| Д/д | Хуулийн этгээдийн нэр | Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл | | | | | Хандив хүлээн авсан | | | Мөнгөн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Регистрийн дугаар | Хаяг, утасны дугаар | Үүсгэн байгуулагдсан огноо | Үйл ажиллагааны чиглэл | Хуулийн этгээдийн хэлбэр | Огноо | Банкны нэр | Дансны дугаар | | |
| Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон | | | | | | | | | | | |
| 1 | байхгүй | | | | | | | | | 0 | |
| 2 | | | | | | | | | | | |
| Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд | | | | | | | | | | | |
| 1 | байхгүй | | | | | | | | | 0 | |
| 2 | | | | | | | | | | | |

*Санамж : Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.*

Тамга, тэмдэг

Хянасан : Ерөнхий нарийн бичгийн дарга ................................/С. Батбаатар/

2023.04.11

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 04. 18 № 903

танай ______ -ны № ______ -т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН
НАМД

Мөрийн хөтөлбөрт хийсэн аудитын
дүгнэлт хүргүүлэх тухай

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох Иргэний зориг Ногоон Намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2022-2023 оны төсвийн төсөөлөл, "Алсын хараа 2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэний зориг Ногоон намын Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар дүүргийн Иргэний зориг Ногоон намын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг Нийслэл, Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт....1..... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

БАТЛАВ. СҮХБААТАР ДҮҮРГИЙН БАГА ХУРАЛ

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАХИН БОЛОН НӨХӨН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Орон нутгийн хөгжлийн сангийн орлого, зарлагын ил тод болгох**

1. Иргэдэд хяналт хийх боломжийг бий болгоно.
2. Дүүргийн иргэдийн төлөөлчдийн хурлын өнгөрсөн хугацаанд хийсэн үйл ажиллагаанд хяналт мониторинг судалгаа хийж сонгогчдод хүргүүлнэ.
3. Засаг даргын үйл ажиллагаанд мониторинг хийж нээлттэй тайланг иргэдэд хүргэнэ.
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөрүүдэд иргэдийг хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.
5. Иргэд - сонгогчид чөлөөлтэй хамтран ажиллах шуурхай мэдээллийн төвийг сошиал болон бусад хэлбэрээр бий болгож тогтмол хамтарч ажиллана.
6. Тойрог хүрээнд гэмт хэрэг гарч болзошгүй нөхцөл байдлыг арилгахын төлөө ажиллана.
7. Эрүүл тайван аюулгүй амьдрах орчныг бий болгоно.
8. Иргэний зориг ногоон намын тэргүүлэх зорилт болох ногоон үзэл баримтлалын хүрээнд иргэдийг идэвхитэй хамтарч ажиллах нөхцлийг бий болгох. Ирээдүйн сайн иргэншлийн төлөө ажиллана.
9. Сургууль, цэцэрлэг өсвөр үеийн суралцах, амьдрах орчины соёлжилтийг дэмжин чадавхижуулж ажиллана.
10. Ногоон соёл иргэншлийн төлөөх сайн дурын үүсгэл санаачлагыг дэмжих хамтын клубууд байгуулан ажиллана. (Эрх зүй, Эдийн засаг, Нутгийн удирдлага, Нээлттэй засаглал, Ил тод байдал иргэдийн оролцоо хяналт мониторинг)

**ЭРХЭМ ХҮНДЭТ НИЙСЛЭЛЧҮҮДЭЭ!**
**ТӨРӨЛХ ХОТЫНХОО ЭЗЭН НЬ БАЙЖ НИЙСЛЭЛ УЛААНБААТАРТАА ТЭГШ ЭРХТЭЙ ХАНГАЛУУН ЖАРГАЛТАЙ АМЬДАРЦГААЯ!**

1117145633
УХА0612 9077278